

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.30

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ, түүнийг үзүүлэх байгууллагад тавигдах нийтлэг шаардлага	MNS :2024
General requirements for child development services and support activities	

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2024 оны ... дугаар сарын ... -ны өдрийн дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс хүчинтэй.

1 Зорилго

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээг үзүүлэхэд тавих нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэхэд оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ, үйл ажиллагаанд хамаарна.

3 Норматив эшлэл

Энэ стандарт нь Олон улсын болон Монгол Улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын баримт бичгүүдэд суурилсан бөгөөд эдгээрийг нэгэн адил дагаж мөрдөнө. Үүнд:

- Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) Хүүхдийн эрхийн тухай Конвенц;
- Хүүхдийн эрхийн тухай хууль;
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- MNS 5852:2017, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага;
- MNS 6620:2016, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага;
- MNS 6417:2013, Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвд тавих нийтлэг шаардлага;
- MNS 6949:2021, Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага;
- MNS 5538:2005, Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ. Нийтлэг шаардлага;
- MNS 6040:2019, Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага;
- MNS 6418:2013, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих шаардлага;
- MNS 6419:2021, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага;
- MNS 7012:2023, Өсвөр үе залуучуудын хөгжлийн төв, үйлчилгээний нийтлэг шаардлага;
- MNS 5633:2023, Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага;
- MNS 6752:2019, Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ;

- MNS 6981:2022, Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Соёлын төв, соёлын ордон. Орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага;
- MNS 5742:2019, Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага.

4 Нэр томъёоны тайлбар

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

4.1

Хүүхэд

Төрсөн цагаас нь эхлэн 18 нас хүрээгүй хүн бүрийг¹;

4.2

Хүүхдийн хөгжил

Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг²;

4.3

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа

Хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон танин мэдэхүй, оюун ухааны, нийгэмшихүйн, бие махбодын хөгжлийн хэрэгцээг хангах болон хөгжлийн хэрэгцээ хангадахгүй байх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн, оролцоог дэмжсэн олон талт хамтын үйл ажиллагаа³;

4.4

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ

Хүүхдийн хөгжлийн онцлогт тулгуурлаж, хэрэгцээг хангахад чиглэсэн, нийгэмшихүй, танин мэдэхүйн, бие махбодын хөгжлийг дэмжих, чадавхыг нэмэгдүүлж, тогтвортой өөрчлөлт гаргахад чиглэсэн үйлчилгээг⁴;

4.3.1

Хүүхдийн бие махбодын хөгжлийг дэмжих үйлчилгээ

Хүүхдийн бие махбодын хөгжлийг дэмжиж, дасгал хөдөлгөөнийг амьдралын хэвшил болгох, хөдөлгөөний дадал олгох, хүүхдийн бие махбодын гадаад, дотоод өсөлт, өөрчлөлтийг дэмжих үйлчилгээг;

4.3.2

Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ

Хүүхдийн оюуны ухаан, танин мэдэхүйн хөгжил, өөрчлөлтийг дэмжих үйлчилгээг;

4.3.3

Нийгэмшихүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ

Хүүхдийн давуу чанар, бие хүний хөгжил, харилцааны чадваруудыг дэмжих үйлчилгээг;

4.4

Хүүхдийн оролцоог дэмжих үйлчилгээ

Хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулах, нийгэмд эзлэх байр суурьт дорвитой бөгөөд тогтвортой өөрчлөлт гаргах, утга төгөлдөр, ёс зүйтэй оролцоог хангах хүүхдийн оролцоог хөгжүүлэх, дэмжих үйлчилгээг;

¹ НҮБ, Хүүхдийн Эрхийн Конвенц, 1990

² Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016

³ ГБХЗХГ (2022) Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зураглал

⁴ ГБХЗХГ (2022) Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зураглал

4.5**Хүүхдийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох**

Хүүхдийн хөгжилд тулгамдаж буй асуудал, хэрэгцээг тодорхойлох, хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг үнэлэх, хүүхдийн хөгжил оролцоог дэмжих орчинд дүн шинжилгээ хийхэд ашиглах батлагдаж, туршигдсан арга, хэрэгсэл⁵;

4.6**Хүүхдийн оролцоо**

Хүүхэд бүр мэдээлэл олж авах, өөрийгөө хөгжүүлэн хамгаалах, санаа бодлоо илэрхийлэх, дуу хоолойгоо хүргэх, гэр бүл, сургууль, олон нийтийн бүхий л орчинд өөрт хамаатай шийдвэр гаргахад хариуцлагатай оролцооноор нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулан, сайн сайхан хөгжлийг дэмжих байгууллага, хөдөлгөөн үүсгэх, нэгдэн орох эрх эдлэх⁶;

4.7**Арга зүй**

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ болон үйл ажиллагааг сонгон хэрэгжүүлэх, зохион байгуулах үндэслэлийг тодорхойлсон тулгуур зарчмуудын нэгдэл⁷;

4.8**Нийгмийн ажилтан**

Баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтан⁸;

4.9**Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан ажилтан**

Хүүхдийн хөгжил оролцооны чиглэлээр баримталж буй бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг үнэлэх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, сургалтад хамрагдаж мэргэшсэн ажилтан.

5. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны нийтлэг зарчим

- 5.1 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ, үйл ажиллагаа нь эерэг өөрчлөлтөд чиглэсэн, хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй хандсан, амьдарч буй орчин нөхцөл болон алслагдсан байдлаар хязгаарлагдахгүй;
- 5.2 Хүүхэд үзэл бодол, дуу хоолойгоо чөлөөтэй илэрхийлэх орон зай, цаг хугацаа бүхий аюулгүй, хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг хүүхдийг хүрээлэн байгаа орчинд бий болгоно;
- 5.3 Хүүхдийн хөгжлийн онцлог, авьяас, чадавх, сонирхол, хэрэгцээнд суурилан тэдэнд урам зориг, дэмжлэг үзүүлэх, хүүхдийг оролцуулан идэвхжүүлж, цаг хугацааг үр бүтээлтэй өнгөрүүлэх;
- 5.4 Хүүхдийн санал, санаачилгыг дэмжиж оролцоог хангана.
- 5.5 Хүүхэд оролцсон үйл ажиллагааны үр дүнг үнэлэн, өөрчлөлтийг хянах, үр дүнг түгээн дэлгэрүүлэх, дараагийн үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулдаг эргэх холбоотой байна.
- 5.6 Хүүхдийн хөгжлийн дэмжих үйл ажиллагааг үзүүлэхдээ хүүхдийн онцлогт тулгуурлаж, хэрэгцээг хангахад чиглэсэн, нийгэмшихүй, танин мэдэхүйн, бие махбодын хөгжил, оролцоог дэмжих үйлчилгээг цогцоор үзүүлнэ.

⁵ ГБХЗХГ (2022) Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зураглал

⁶ Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

⁷ Мөн энд

⁸ Нийгмийн ажил үйлчилгээний нийтлэг шаардлага

5.7 Хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсанаараа хүүхэд хохирох ёсгүй бөгөөд хамгаалагдсан байна.

6. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг дараах чиглэлээр тэгш хүртээмжтэй цогц байдлаар үзүүлнэ. Үүнд:

- 6.1. Хүүхдийн бие махбодын хөгжлийг дэмжих үйлчилгээ;
- 6.2. Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ;
- 6.3. Нийгэмшихүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ;
- 6.4. Хүүхдийн оролцоог дэмжих үйлчилгээ.

7. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих шаардлага

- 7.1 Монгол Улсад бүртгэлтэй байна.
- 7.2 Үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий хүүхдэд ээлтэй, аюулгүй хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.
- 7.3 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага нь үйлчилгээнийхээ онцлог, чиглэлд тохирсон бодлого, хөтөлбөртэй байна.
- 7.4 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх ажилтны баримтлах ёс зүйн дүрэм, хүүхэд хамгааллын бодлого, журам, заавартай байна.
- 7.5 Байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлог, чиглэлд тохирсон стандарт, удирдамжийг баримтална.
- 7.6 Хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүртгэл, мэдээллийн санд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг тухай бүртгүүлж, үйл ажиллагаагаа хагас, бүтэн жилээр тайлагнана.
- 7.7 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага нь ажилтнаа дараах чиглэлээр мэдлэг, чадварыг эзэмшүүлнэ.
 - 7.7.1 Салбар дундын хамтын ажиллагааг зохицуулан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаа зохион байгуулах;
 - 7.7.2 Хүүхдийн хөгжлийн давуу болон сул талыг тодорхойлох, судалгаа дүн шинжилгээ хийх, үр дүнд суурилсан үйл ажиллагаа арга хэмжээг зохион байгуулах;
 - 7.7.3 Шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, хүний хөгжлийн болон хүүхэд, өсвөр үеийн хөгжил, онцлог, ялгаатай байдлын талаар;
 - 7.7.4 Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хөгжүүлэх, оролцоог дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах;
 - 7.7.5 Сайн дурын ажилтныг чадавхжуулах, сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах.

8. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх ажилтанд тавих шаардлага

- 8.1. Тухайн үзүүлэх үйлчилгээний чиглэлээр боловсрол, ур чадвар эзэмшиж, мэргэшсэн байна.
- 8.2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд заавал хамрагдаж, мэргэжлийн байгууллагаар сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эрүүл гэдгээ тогтоолгоно.
- 8.3. Эрүүгийн хариуцлага, гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаагүйг Цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сангийн “Тодорхойлолт”-оор нотолно.
- 8.4. Хүүхдийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, нөхцөл байдлыг үнэлэх, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хүүхэдтэй ажиллах, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн байна.

9 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зохион байгуулалт

- 9.1 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлоход боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын болон шүүх засаглалын байгууллагын төлөөлөл, иргэний нийгмийн болон хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагууд хамтарч оролцоно.
- 9.2 Хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг мэргэжил, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.
- 9.3 Хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын хүүхдийн хөгжил, оролцооны асуудал хариуцсан ажилтан нь хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах, үнэлгээ хийх үүрэгтэй.
- 9.4 Хүүхдийн хөгжлийг дэмжигч, оролцогч, сонирхогч бүх талууд хүүхдийн эрхийг дээдэлсэн ёс зүйтэй хамтын ажиллагаанд тулгуурлан үйл ажиллагааг тасралтгүй харилцан уялдаатай хэрэгжүүлнэ.
- 9.5 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг салбар дундын хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 9.6 Хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийхдээ хүүхдийн оролцоог хангана.
- 9.7 Үйлчилгээ үзүүлэх байгууллага нь хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээтэй холбоотой тусгай шаардлагыг мөрдөж, үйлчилгээнийхээ чанарт хариуцлага хүлээнэ.

10. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх үе шат

10.1 Хүүхдийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох

- 10.1.1 Хүүхдийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлохдоо нөхцөл байдлын үнэлгээ хийх журам болон хүүхдийн хөгжлийн түвшин хэрэгцээг тодорхойлох батлагдаж, нотлогдож туршигдсан хэмжүүр тестийг ашиглана.
- 10.1.2 Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан, хүүхдийн арга зүйч хүүхдийн хөгжлийн үйлчилгээний хэрэгцээ, нөхцөл байдлыг тодорхойлж, үйлчилгээг хүргэнэ.
- 10.1.3 Хүүхдийн хөгжлийн хэрэгцээг бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийн хүрээнд тодорхойлно.
- 10.1.4 Бага насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлохдоо хооллолт, эрүүл мэнд, гэр бүлийн орчин, асаргаа, халамжийг нэмж судална.
- 10.1.5 Өсвөр насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлохдоо хөгжлийн давуу чанар болон оролцоог нэмж судална.

10.2 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төлөвлөх үе шат

- 10.2.1 Хүүхдийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлсон нөхцөл байдлын болон орчны үнэлгээнд үндэслэн үйлчилгээний төрөл, хэлбэр, хугацааг тодорхойлж, төлөвлөнө.
- 10.2.2 Хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг дэмжих үйлчилгээнд хамруулна.
- 10.2.3 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд бүх талуудын оролцоог тодорхойлж, сонирхол, хэрэгцээнд тулгуурлан төлөвлөнө.

10.3 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хэрэгжүүлэх

- 10.3.1 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төлөвлөгөөний дагуу мэргэжлийн түвшинд оролцогч талууд хэрэгжүүлнэ.

10.3.2 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төлөвлөгөөний дагуу үзүүлэхдээ хүүхдийн эрхийг дээдлэн хүндэтгэлтэй хандаж, үйлчилгээг цогц байдлаар тасралтгүй хэрэгжүүлнэ.

10.3.3 Хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан ажилтны үнэлгээ, зөвлөмж, төлөвлөгөөний дагуу үйлчилгээг чанартай, үр дүнтэй үзүүлнэ.

10.4 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төгсгөх, үнэлэх

10.4.1 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зорилго, төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

10.4.2 Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хөгжилд гарсан ахиц өөрчлөлтийг үнэлнэ.

ТӨГСӨВ.